



NATIONAL FEDERATION  
OF PASTURE USER  
GROUPS OF HERDERS



IYRP INTERNATIONAL  
YEAR OF  
RANGELANDS AND  
PASTORALISTS



## БЭЛЧЭЭРИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТ, ЭКОЛОГИЙН ЧАДАВХЫН 2021 ОНЫ ШАГНАЛ

### Сонгон шалгаруулах зарчим:

- “Бэлчээрийн Тогтвортой Менежмент, Экологийн Чадавхын 2021 оны шагнал”-ыг малын тоог бэлчээрийн экологийн даацад тохируулан зохистой ашигласан Бэлчээр ашиглах хэсэг, бүлэг (БАХ), Ойн нөхөрлөл, Байгалийн нөөцийн менежментийн бүлэг хамтлагт (БНМ) олгох зорилгоор Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо (МБАНХ), Бэлчээр болон Нүүдлийн Мал Аж Ахуй Эрхлэгчдийн Олон улсын жилийг дэмжих “Төв Ази ба Монголын” бүс, Байгаль Орчин ба Хөгжлийн “Жасыл” Холбоо, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам зэрэг байгууллагууд шалгаруулж олгож байна.
- Шагнал олгох журмыг 2021 оны 7-р сарын хугацаанд ИССА консорциумын Азийн бэлчээрийн семинарын үеэр зарлах бөгөөд “ЖАСЫЛ” Холбоо, МБАНХ, ХХААХҮЯ-ны вебсайтууд дээр дараах холбоосуудаар <http://cbnrm.mn>, [www.greenmongolia.mn](http://www.greenmongolia.mn) мөн “ЖАСЫЛ” Холбооны “Экологийн чадавхи” сонинд тавигдана.
- Шагналын эздийг тодруулах эцсийн үе шат нь 2021 оны 9-р сарын дундуур НҮБ-ийн Ерөнхий Асамблейны хуралдаанаар IYRP-ийн талаарх Монгол Улсын саналыг батлах үеэр шагналын эздийг зарлана.
- Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг бүлгийн гол зорилт бол бэлчээрийн экологийн чадавхтай малын тоог зохицуулах, тохируулах хариуцлагатай үйл ажиллагаа бөгөөд бэлчээр нутгаас үзүүлж буй байгаль орчны үйлчилгээг ашиглаж, бэлчээрийн газар ашигласнаар орлогоо нэмэгдүүлэх замаар бэлчээрийн нутаг дэвсгэрийг тогтвортой, хамт олны оролцоотой удирдах явдал юм.

### Сонгон шалгаруулалтад мэдээлэл өгөх хугацаа :

Орон нутгийн БНМ, БАХ-ууд сонгон шалгаруулалтад оролцох өргөдлөө хавсаргасан хүснэгтийн дагуу гаргаж ирүүлнэ.

Бүрэн бөглөсөн өргөдлийг хүлээн авах сүүлийн хугацаа 2021 оны 8-р сарын 30-ны

өдөр байна.

### **Сонгон шалгаруулалтын шалгуур :**

Бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлэг ба байгалын нөөцын хамтын менежментийн нөхөрлөлүүдийн бэлчээрийг хамгаалах, нутаг орноо хөгжүүлэхэд ашиглах шагнал гардуулах ёслолыг Төв Азийн Бэлчээр Ашиглах Холбоо (ТАБАХ), “Жасыл” Холбоо, МБАНХ болон Бүс Нутгийн IYRP дэмжих бүлэг (RISG)-тэй хамтран зохион байгуулна.

Уламжлалт мэдлэг ухаанаа ашиглаж, орон нутгийн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээхэд амжилт гаргаж, шалгарсан БАХ ба БНМ-ийн нөхөрлөлүүдэд Гэрчилгээ болон 1,450,000 төгрөг (500 ам.доллар) –ийн шагнал олгоно. Шагнал олгох үйл ажиллагааг дээр дурдсаны дагуу 2021 оны 9-р сард COVID 19-ийн нөхцөл байдалтай уялдуулан цахим хэлбэрээр олгох болно.

### **Сонгон шалгаруулах Хороо :**

5 хүний бүрэлдэхүүнтэй сонгон шалгаруулах хороонд “ЖАСЫЛ” холбоо, МБАНХ, ХХАХҮЯ, “Амьдралын нутаг дэвсгэрийн Монголын Ажлын Хэсэг” , Бэлчээр болон Нүүдлийн Мал Аж Ахуй Эрхлэгчдийн Олон улсын жилийг дэмжих “Төв Ази ба Монголын” бүс тус бүрээс нэг хүн оролцоно. Сонгон шалгаруулах хорооны шийдвэр эцсийн байна.

- Их дээд сургуулиудын цөөн хэдэн бие даасан шинжээч/эрдэмтдийн тусалцаатайгаар шаардлагатай тохиолдолд нэмэлт үнэлгээ хийлгэж болно.

### **Сонгон шалгаруулалтад өргөдөл гаргах загвар:**

1. БАХ, болон, БНМ-ийн нөхөрлөлийн нэр: (Хэсэг, бүлэг, нөхөрлөлийн ахлагчийн 3x4 хэмжээтэй фото зургийг хавсаргана)

2. Оршин суух хаяг: Аймаг, сум, хороо, баг, газарзүйн байршил

3. Шаардлагатай үед холбоо барих утас, гар утас, иргэний үнэмлэхийн дугаар, и-мэйл хаяг, facebook

4. Нөхөрлөл, бүлэг, хэсгийн гишүүдийн тухай мэдээлэл, БАХ эсвэл БНМ-ын нөхөрлөлийн газрын нийт талбай, малын тоо (малын төрөл тус бүрээр )

(Нөхөрлөл, бүлэг, хэсгийн тухай нэмэлт мэдээлэлийг нэг хуудсанд багтааж хавсаргасан байх)

5. Бэлчээрийн даацыг тохируулах, нүүдэллэх, бэлчээрийг өнжөөх, сэлгэх үйл ажиллагааны мэдээлэл.

6. Бэлчээрийн нөхөн сэргээлт, хамгаалах талаар хийсэн үйл ажиллагааны талаар

дэлгэрэнгүй мэдээлэл,

7. Үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний борлуулалт, сав баглаа, хаягжилт ашиглаж мөшгөх тогтолцоог нэвтрүүлсэн байдал, орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийн талаар мэдээлэл

8. Мал, бэлчээрийн даац, биологийн олон янз байдлыг хамгаалах, амьжиргааг сайжруулах арга хэмжээний талаар цөөн тооны сайн чанарын гэрэл зураг хавсаргах.

Өргөдөл гаргасан хэсэг, бүлэг, нөхөрлөлийн ахлагчийн нэр ба гарын үсэг /

### Өргөдөл хүргүүлэх хаяг :

1. Хижаба Ыханбай,  
Жасыл Холбоо,  
Баруун Сэлбийн-15, Улаанбаатар-11,  
ШУА-ийн 2-р байр # 341 тоот  
Гар утас: 99282205  
Ажлын утас: 976-11-329619  
И-мэйл хаяг: [jasil\\_ngo05@yahoo.com](mailto:jasil_ngo05@yahoo.com)  
Веб хаяг: <http://cbnrm.mn>

2. Ням-Очирын Ганхуяаг ,  
МБАНХ  
Хаяг: Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбооны байр,  
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага Тойруу, 22-20А  
Утас: (+976) 9811 3747  
И-мэйл: [info@greenmongolia.mn](mailto:info@greenmongolia.mn)  
Веб хаяг: [www.greenmongolia.mn](http://www.greenmongolia.mn)